



1 ИНФЛЯЦИЙН ТАЛААРХ ИРГЭДИЙН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА¹

Инфляцийн талаарх иргэдийн хүлээлтийн түүвэр судалгааг 2016 оны 9 дүгээр сард Улаанбаатар хотын 9 дүүргийн 1,000 иргэнийг хамруулан санамсаргүй түүврийн аргаар гүйцэтгэлээ. Судалгаанаас дараах үр дүнгүүд гарсан бөгөөд иргэд ирэх 12 сарын хугацаанд:

- Инфляци өнөөгийн түвшинд;
- Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш чангарна;
- Зээлийн хүү өснө;
- Эдийн засгийн ерөнхий төлөв байдал муудна;
- Өрхийн санхүүгийн байдал муудна гэсэн хүлээлттэй байна.


1.1 Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

- Насны бүтцийн хувьд 55.6% нь 25-44 насны;
- Боловсролын түвшнээр авч үзвэл 92.0% нь бүрэн дунд болон дээд боловсролтой;
- Ажилладаг салбараар авч үзвэл бөөний болон жижиглэн худалдааны салбарт 37.5% нь ажилладаг, 15.5% нь үйлчилгээний салбарт;
- Ажил эрхлэлтийн байдлыг авч үзвэл 45.9% нь хувийн байгууллага, 22.0% нь төрийн албанд ажилладаг бол 24.3% нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг;
- Өрхийн орлогын түвшнээр авч үзвэл судалгаанд оролцогчдын 62% нь 600 мянга хүртэлх төгрөгийн (зээлийн төлбөрийн дараах орлого) орлоготой өрхүүд байлаа.


1.2 Инфляцийн хүлээлт

Хүлээлтийн чанарын хариултаас харвал иргэдийн 61% нь ирэх 12 сард үнийн түвшин ерөнхийдөө өснө гэж үзсэн бөгөөд үүнээс 36% нь үнийн түвшин илүү хурдацтайгаар өснө (өмнөх судалгааны дүнгээс 10 нэгж хувиар өссөн), 25% нь үнэ өснө гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй гэж хариулжээ.

Зураг 1-1: Ирэх 12 сарын хугацаанд үнийн түвшин хэрхэн өөрчлөгдөх вэ?




Зураг 1-2: Инфляцийн талаарх иргэдийн хүлээлтийн чиглэлийн индекс




Эх сурвалж: Монголбанк, инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

¹ Инфляцийн талаарх иргэдийн хүлээлт улирал бүр, ААН болон шинжээчдийн судалгаа хагас жилд нэг удаа хийгддэг.

Зураг 1-5: Иргэдийн ирэх 12 сарын хугацаан дахь валютын ханшийн талаарх хүлээлт




Зураг 1-6: Иргэдийн ирэх 12 сарын хугацаан дахь валютын ханшийн талаарх хүлээлт /орлогын түвшнээр/




Тайлбар: Чиглэлийн индекс нь [-1;1] завсарт утгаа авна.]0;1] ханш суларна, [0] хэвэндээ байна,]0;-1] чангарна.

Судалгаанд оролцогчдын ихэнх хувь нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулралтад гадаад орчин, төсвийн үрэлгэн байдал болон гадаад өр хамгийн ихээр нөлөөлж байна гэж үзжээ /Зураг 1-7/. Төгрөгийн ханш суларснаар иргэдийн хэрэглээнд маш их, их сөрөг нөлөө үзүүлж байна гэж судалгаанд оролцсон иргэдийн 69% нь хариулжээ /Зураг 1-8/.

Зураг 1-7: Ханшийн сулралтад нөлөөлж буй хүчин зүйлс



Зураг 1-8: Ханшийн хэрэглээнд үзүүлж сөрөг нөлөө



Эх сурвалж: Монголбанк, инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

1.4 Зээлийн хүү

Зураг 1-9: Иргэдийн ирэх 12 сарын хугацаан дахь зээлийн хүүний талаарх хүлээлт



Судалгаанд хамрагдсан иргэдийн хувьд ирэх 12 сарын хугацаанд зээлийн хүү өснө гэсэн хүлээлттэй байна. Зураг 1-9-ээс харахад тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2016 оны 9 дүгээр сарын байдлаар өмнөх улирлаас 1.0 нэгж хувиар өсч 20.1 хувьд хүрчээ.

Энэ хөдөлгөөнтэй зээлийн хүүний хүлээлтийн чиглэлийн индекс адил чиглэлд өөрчлөгдсөн байна.


Тайлбар: Чиглэлийн индекс нь [-1;1] завсарт утгаа авна.]0;1] ханш суларна, [0] хэвэндээ байна,]0;-1] чангарна.




1.5 Иргэдийн орлого

Судалгаанд хамрагдсан иргэдийн ихэнх нь ирэх 12 сарын хугацаанд эдийн засгийн төлөв байдал муудна гэсэн хүлээлттэй байна. 2016 оны 2 дугаар улирлын байдлаар эдийн засгийн өсөлт 1.4%-тай гарч буурсан нь иргэдийн хүлээлтэд нөлөөлсөн байхыг үгүйсгэхгүй /Зураг 1-10/.

Зураг 1-10: Иргэдийн ирэх 12 сарын хугацаанд эдийн засгийн төлөв байдлын талаарх хүлээлт



Зураг 1-11: Иргэдийн ирэх 12 сарын хугацаанд өрхийн санхүүгийн байдлын талаарх хүлээлт



Тайлбар: Чиглэлийн индекс нь [-1;-1] завсарт утгаа авна. [0;1] эдийн засгийн байдал сайжирна, [0] хэвэндээ байна, [0;-1] муудна.

Өрхийн санхүүгийн байдлын чиглэлийн индекс өмнөх судалгааны дүнгээс огцом буурч “**өрхийн санхүүгийн байдал муудна**” гэсэн мужид шилжсэн байна. Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ харьцангуй тогтвортой байж инфляцийн түвшин буурсан ч иргэдийн бодит орлого төдийлөн нэмэгдэхгүй байна. Иргэд ирэх нэг жилийн хугацаанд эдийн засгийн ерөнхий төлөв байдал муудахын хирээр өрхийн санхүүгийн байдал муудна гэсэн хүлээлттэй байна /Зураг 1-11/.

1.6 Дүгнэлт

Иргэд ирэх 12 сарын хугацаанд эдийн засгийн ерөнхий төлөв байдал төдийлөн сайжрахгүй гэсэн хүлээлттэй байна. Тухайлбал, инфляци өнөөгийн түвшинтэй ойролцоо, зээлийн хүү өснө, өрхийн санхүүгийн байдал үргэлжлэн муудна гэсэн хүлээлттэй байгаа үр дүн гарлаа.

Иргэд ийнхүү хүлээж байгаа нь нэг талаас инфляци идэвхжихгүй байхыг илтгэж байгаа хэдий ч, нөгөө талдаа өрхийн хэрэглээ буурах, жижиглэнгийн борлуулалт үргэлжлэн саарах, улмаар эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлт буурах зэргээр одоогийн эдийн засгийн хүндрэл гүнзгийрэх эрсдэл өндөр байгааг илтгэж байна.